

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**ЗОРИЛГО: ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, БАГИЙН МАНЛАЙЛЛЫГ ДЭМЖИЖ,
БАЙГУУЛЛАГЫН СОЁЛЫГ ТӨЛӨВШҮҮЛНЭ.**

Зорилт 1. Бүс нутагт төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээний тоо, төрлийг нэмэгдүүлэн, үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээтэй уялдуулан ажиллана.

Зорилт 2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулан ажиллана.

Зорилт 3. Эмч эмнэлгийн мэргэжилтний мэдлэг ур чадвар, ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулж нийгмийн баталгааг дэмжиж ажиллана.

Зорилт 4. Халдварт болон халдварт бус өвчлөлийн тэргүүлэх чиглэлийн дагуу нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг зохион байгуулна.

Зорилт 5. Эмнэлгийн ээлтэй орчинг бүрдүүлж, байгууллагын соёлын хандлага, дадлыг сайжруулж ажиллана.

Зорилт 6. Цахим эрүүл мэндийн тогтолцоог хөгжүүлж ажиллана.

Зорилт 7. Эмнэлгийн менежмент, эмнэлгийн үйл ажиллагааны удирдлагыг оновчтой зохион байгуулж ажиллана.

Зорилт 8. Гүйцэтгэлд суурилсан төлөвлөлт, санхүүжилтийн ил тод байдал, шилэн дансны хуулийг хэрэгжүүлэн ажиллана.

Өвөрхангай аймаг БОЭТөвийн оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дараах бодлогын бичиг баримтуудаас чиг үүрэгт хамааралтай арга хэмжээнүүдийг тусгасан. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2025 онд хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээ
2. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван үндсэн чиглэлд 2025 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээ
3. Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 13-ны 01 тоот албан даалгавар
4. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 2025 онд шинээр 22 арга хэмжээ, тогтмол зохион байгуулагддаг 20, нийт 42 арга хэмжээ төлөвлөсөн.